

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Төв Ази, Ойрхи Дорнод, Хойд Африкийн эмэгтэйчүүдэд зориулсан залбирал 2

Төв Азийн "Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэлийн багуу д" радио, сошиал медиа платформ, SD карт, флаш дискээр дамжуулан эмэгтэйчүүдэд Сайн мэдээг хүргэж байна. Сонсогчдын нийтлэг хэрэгцээг хангахад чиглэсэн хөтөлбөрийн сэдвүүд нь хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл, үргүйдэл, дутуу төрөлт, соёлын бэрхшээлийг багтаасан бол нөгөө талаар үл итгэх, ичгүүр, гэм буруу, үгүйсгэл зэрэг сэтгэл санааны хямралыг хөндсөн нэвтрүүлэгүүдийг хүргэж байна. Мөн тэд алслагдсан тосгонд очиж Библи уншиж, залбирахад нь тусалдаг. Удирдагчдыг сүнслэг байдлаар хүчирхэгжүүлж, сүм хийдийн шашны эрх чөлөөг хамгаалах хууль батлагдахын төлөө залбирна үү.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Бурхан минь, Каракалпакстанд ид шидийн зан үйл хийдэг эмэгтэйчүүд Танаас авралыг авч, амьдралын хүч чадал Танаас ирдэг гэдэгт итгэх болтугай. (Лев. 19:31)
2. Амьд үлдэхийн тулд хүчээр олон эхнэртэй хүмүүсийн хоёр, гурав дахь эхнэр бол гэрлэхээс өөр аргагүйд хүрсэн Тажик залуу охидод амьдрах итгэл найдварыг Эзэн минь Та өгөөч. (1 Петр. 3:7)
3. Аав аа, Найдвар дотор эмэгтэйчүүд нэвтрүүлэгийг өөр өөр шашинтай Киргизд хүмүүс сонсож байгаад талархаж байна. Таны үнэн тэднийг чөлөөлж, гэр бүлд нь авралыг авчрах болтугай. (Иохан 8:32)
4. Эзэн минь, Казахстан дахь өрх толгойлсон эхчүүдэд

шударга хөдөлмөрөөр өөрсдийгөө болон гэр бүлээ тэжээхийн тулд ажиллах боломжийг олж авахад нь туслаач. (Кол. 3:23)

5. Аав аа, Иордан дахь дүрвэгч эмэгтэйчүүдэд Та хамгаалалт, дэмжлэгийг өгөх хэн нэгнийг илгээгээч. Тэднийг шинэ нийгэмдээ суурьших үед нь итгэл найдвар, амар амгалан, тогтвортой байдал руу Та хөтлөх болтугай. (Мат. 11:28)
6. Эзэн минь, бид Танаас Туркменистан дахь итгэгчдэд гэр бүлээрээ чуулганд хамрагдаж, үл итгэгчдийн эсэргүүцэлтэй тулгарсан ч гэсэн итгэлээ сахих арга замыг зааж өгөхийн төлөө гуйж байна. (Үйлс 2:42)
7. Бурхан минь, Узбекистан дахь эцэг эхчүүд хүүхдүүдээ Таны үгийн дагуу хүмүүжүүлж, хүмүүжүүлэхдээ Танаас мэргэн ухааныг эрэлхийлэхийн төлөө бид залбирч байна. (Сур. 22:6)
8. Эзэн минь, бид Египет, Тунисын жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийг хамгаалж, хүчирхийлэлээс гарах ямар нэг арга зам олохын төлөө залбирч байна. (Дуу. 9:9)
9. Аав аа, Хойд Киприйн зүрх нь шархалсан эмэгтэйчүүдийн хоргодох газар, итгэл найдвар болсон сүм чуулган бэлтгэгдэхийн төлөө бид Танаас гуйж байна. (Дуу. 147:3)
10. Бид өөрсдийн итгэл үнэмшлээрээ хавчигдаж байгаа Туркийн Христэд итгэгчдийн төлөө залбирч байна. Эзэн минь, итгэлийн ахан дүүст маань Даниел шиг эр зориг, амар амгаланг өгч, ямар ч хавчлагыг даван туулах хүчийг өгөөрэй. (Дан. 6:22)
11. Бурхан минь, бид Ойрхи Дорнодын багуудын дижитал платформуудын тасралтгүй, тогтвортой байдлын төлөө залбирч байна. Сонсогчидтойгоо харилцаа тогтооход нь манай багуудад мэргэн ухааныг өгөх болтугай. (Дуу. 90:17)
12. Эзэн минь, Узбекистаны ард түмний оюун санааны бэхлэлтүүдийг эвдэж, Сатаны дайралтыг ялгаж, зоригтой, шийдэмгий байдлаар эсэргүүцэхэд нь туслаач. (Иаков 4:7)
13. Аав аа, Христэд итгэснээсээ болж нийгмийн дарамт шахалт, гадуурхалд өртөж буй Бахрейнд эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлж, хамгаалах болтугай. (Дуу. 27:1)
14. Бурхан минь, бид Тан руу хандан Каракалпакстан дахь хадам ээж, бэрийн харилцаа сэргэхийн төлөө залбирч байна. Бие биенээ хүлээн зөвшөөрч, хайраар хандах болтугай. (2 Кор. 13:11)

15. Аав аа, Сирийн эмэгтэйчүүд үндэстний мөргөлдөөн, үймээн самуун дунд Христийн хайр, амар амгаланг мэдрэх болтугай. Гашуудаж буй хүмүүсийг тайвшруулж, нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийг хангаж, хамгаалах болтугай. (Дуу. 23:4)

16. Эзэн минь, эдийн засгийн хүнд хэцүү үед Туркийн удирдагчдыг удирдан чиглүүлж, мэргэн ухааныг өгөөч. Эмч нар санхүүгийн байдлаас болж гадагшаа дүрвэж тул эмчийн хомсдол үүсч байна. Аав аа, Та бүхнийг шийдвэрлэх болтугай (Ис. 30:21)

17. Бурхан минь, Киргизийн итгэгчдийг эргэн тойрныхоо үл итгэгчидтэй хайр, үнэнийг хуваалцахаад Та бэлтгээч. Хүмүүс Таны Үгээр өлсөж цангах болтугай. (Үйлс 1:8)

18. Эзэн, нөхөр, хадмаасаа гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй Тажик эмэгтэйчүүдэд аюулгүй байдлыг авчраач. Эмэгтэй хүнийг хүндэлдэггүй эрчүүдийн сэтгэл өөрчлөгдөхийн төлөө залбирч байна. (Ис. 60:18)

19. Аав аа, Киргизийн Христэд итгэгч гэр бүлүүдийг ерөөж, хамгаалж, нэгтгэж, тэднийг зовлон зүдгүүрийн эсрэг хүчтэй байхад нь хүчирхэгжүүлээч. Эхнэрүүдэд гэр бүлийнхээ төлөө залбирч, мацаг барьж сурахад нь Та туслаач. (Сур. 31:10)

20. Бурхан минь, Катар дахь консерватив нийгэмлэгийн эмэгтэйчүүдэд сайн мэдээ хүргэхэд Та бидэнд туслаач. Тэд Таныг таньж, Таны тэдэнд өгсөн жинхэнэ үнэ цэнийг олж харах болтугай. (Еф. 2:10)

21. Аав аа, Туркменистанд гэр бүлээ цуцлуулах гэж байгаа хүмүүс сэтгэл санаагаа өөрчилж, гэрлэлтийн харилцаагаа сэргээхийг боломжуудыг эрэлхийлэх болтугай. (Евр. 13:4)

22. Бурхан минь, Туркменистан дахь ажилгүйчүүд ажлын байраар хангагдаж, гэр бүлээ тэжээхэд шаардагдах ур чадварыг эзэмшүүлэх болтугай. (Сур. 16:3)

23. Аав аа, үр хөндөлтийн дараах эмэгтэйчүүдийн сэтгэл зүйг Та эдгээгээч. Христийн сайн мэдээг ард түмэндээ хүргэхийн тулд Төв Ази дахь манай TWR-ийн Найдвар доторх Эмэгтэйчүүдийн багт мэргэн ухааныг өгөөч. (Сур. 2:6)

24. Эзэн Бурхан минь, Узбекистаны итгэгчид Бурханд үнэнч зүрх сэтгэлээрээ үйлчилж, гэр бүлийнхээ эсэргүүцэлтэй тулгарсан ч итгэлдээ тууштай байх болтугай. (1 Кор.15:58)

25. Эзэн минь, Каракалпакстаны удирдагчдад ард иргэдийнхээ эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, үнэ төлбөргүй үзүүлэх зохицуулалтыг хийх мэргэн ухааныг өгөөч. Эмэгтэйчүүдэд өөрийгөө эмчлэхээс илүүтэйгээр хэзээ эмнэлгийн тусламж авах талаар ойлголт өгөхөд Та туслаач. (Сур. 3:13)

26. Бурхан минь, Туркийн ганц бие эмэгтэйчүүд гэр бүлээ тэжээх найдвар, урам зоригийг Танаас олох болтугай. (Хаадын дээд 17:13-16)

27. Эзэн, Арабын Нэгдсэн Эмират улсад сайн түгээхийн

тулд Та итгэгчдийг босгож, хүчирхэгжүүлэх болтугай. (Ром. 1:16)

28. Бурхан минь, гэрлэж, бурханлаг гэр бүлийг бий болгох хүсэлтэй Казахстан дахь ганц бие Христэд итгэгч эмэгтэйчүүдэд бурханлаг нөхрүүдийг Та өгөх болтугай. (2 Кор. 6:14)

29. Аав аа, Мароккод Библийн судлалд суралцаж буй эмэгтэйчүүдийг сүнслэг байдлаар өсөхөд нь тэднийг аюулгүй байлгах болтугай. (Дуу. 32:7)

30. Эзэн минь, нийгмийн дарамттай тулгарсан Алжир эмэгтэйчүүдийг хамгаалж, тэднийг Та хүчирхэгжүүлэх болтугай. (Дуу. 46:1)

31. Бурхан минь, Хойд Кипр дэх Найдварын гүүр гэж нэрлэгддэг TWR Найдвар доторх эмэгтэйчүүд дижитал үйлчлэл үр дүнтэй байж, тусламж хэрэгтэй хүмүүст хүрэх болтугай. (Кол. 1:28) Нийгэм, соёлын сорилттой тулгарч буй Марокко эмэгтэйчүүдэд Бурханы аюулгүй байдал, хамгаалалт байх болтугай. Тэдэнд мэргэжил, боловсрол эзэмших эрх нь нээлттэй болохын төлөө залбирч байна. (Ис. 41:10)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. 10-р сард болох орон нутгийн сонгууль зөв шударга болохын төлөө. Бурханаас эмээдэг хүмүүс гарч ирж, байгаа газартаа өөрчлөлтийг авчрахын төлөө.
2. 2. Малчид өвөл болж хүйтрэхээс өмнө өвлийн бэлтгэлээ хийж бэлтгэлтэй байхын тулд Бурхан минь Та тэднийг хангаач төлөө.
3. 3. Монгол улсын засгийн газрын хурлаар зөв шийдвэрүүд гарч, Монголын ард түмний амьдрал өөрчлөгдөхийн төлөө.

Хүвчлэн

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.